Засгийн газрын хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

# ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ЗАХИРГАА ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ В.АЛТАНЗУЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ.ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | | |
|---|---|---|---|---|
| | | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /биелэлт |
| 1 | 2 | 3 | 4 | 5 |

НЭГ. " БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

***Нийгмийн даатгалын талаар төрөөс барим***

***тлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх,үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах.***

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.1.1 | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион | Хэрэгжүүлсэн дүрэм, журам,заавар,зөвлөмж, аргачлал,чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2024 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг | Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газраас Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан 1 дүрэм, 4 журам, 11 тогтоол, тушаал, шийдвэр, 12 заавар, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | байгуулах. | | зохион байгуулсан байна. | зөвлөмж, 9 аргачлал, чиглэл, 17 тайлбар, судалгаа мэдээлэл ирүүлсэн бөгөөд тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулж үр дүнг тооцон ажиллаж байна. |

ХОЁР. "ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

***Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр , тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах,өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах,нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох,нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах,гүйцэтгэлийг тайлагнах.***

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.1.1 | Тэтгэмжийн материалыг хүлээн авч, тогтоосон тэтгэмжийг хянаж баталгаажуулах | Цахим болон цаасаар ирсэн тэтгэмжийг хянасан тоогоор | Цахим болон цаасаар ирсэн тэтгэмжийг хянасан тоогоор хуулийн хугацаанд хянаж баталгаажуулсан байна | |
| 2.1.2 | Дотоодын хяналт шалгалт, НДЕГ, ННДГ болон хөндлөнгийн хяналт шалгалтаар илэрсэн төлбөр,зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож тайлан, мэдээг заасан хугацаанд гаргах | Тогтоосон акт, барагдуулалтын хувиар | Хуваарийн дагуу тогтооосон актыг 30 хувиар бууруулсан байна. | НДЕГазрын 2024 оны 03 дугаар сарын 19-ний Улсын байцаагчийн актаар тавигдсан "Зун Мен" ХХК-ны нэр бүхий даатгуулагч нарт ногдох 38896000.00 төгрөгийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн нөхөн тайланг тус компаниар гаргуулан хүлээн авч баталгаажуулсан.<br>Эхний хагас жилийн байдлаар |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | нийгмийн даатгалын тайлан илгээхдээ тооцооны алдаа гарган даатгуулагч орхигдуулсан “Цогц уран” ХХК, Зуслан ХҮТөв 2 аж ахуйн нэгж байгууллагын даатгуулагчийн зөрчлийг улсын байцаагчийн актаар арилган нийт 6716287.7 төгрөгийн акт, 3358145.0 төгрөгийн алданги төвлөрүүлэн ажилласан. |

ГУРАВ.” ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ “ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

*Нийгмийн даатгалын тухай хуулв тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалынорон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах*

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3.1.2 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих | Нийгмийн даатгалын байгууллагын сан, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хагас жилийн байдлаар 85 мэдээллийг 07 дугаар сарын 09-ны өдрийн дотор, жилийн эцсийн байдлаар 167 мэдээллийг Shilendans.gov.mn | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 167 мэдээллийг 2024 оны эхний хагас жилийн байдлаар 95.7 хувьтай хугацаандаа | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган Нийгмийн даатгалын байгууллагын сан, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг эхний хагас жилийн байдлаар 85 мэдээллийг хуулийн хугацаанд Shilendans.gov.mn цахим хуудсанд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | цахим хуудсанд байршуулан ДАМГ-т 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ. | мэдээлэл байршуулсан байна. | байршуулж, иргэдийг үнэн, зөв мэдээллээр хангасаныг хяналт тавин ажилласан. |
| 3.2.1 | Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон бусад холбогдох хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон газрын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага болон дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах. | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг нийт аж ахуйн нэгж байгууллагын 20 хүртэл хувьд мөн нийгмийн даатгалын 2-3 сангийн зарцуулалтад дотоодын хяналт шалгалт хийж илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажиллана. | Шалгалтын үр дүнг тухай бүрд нь тооцон, газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулах | Ажил олгогч байгууллагуудад Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөж гарсан зөрчлийг арилгах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажиллаж байна. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/186 тоот тушаалаар батлагдсан Нийгмийн даатгалын байгууллагын хяналт шалгалтын нэгдсэн зааврыг баримтлан ажиллаж байна.<br>Газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 18-ны 02 тоот удирдамжийн дагуу “Паблик кредит” ХХК-д нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилтийн биелэлтийн талаар хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар тухайн байгууллагын 16.500.00,00 төгрөгийн шимтгэлийн өглөгийг төлүүлж үлдсэн өглөг дээр тухайн сарын шимтгэлийг төлөхөөр гэрээ байгуулан мэргэжил арга зүйн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | зөвлөгөө өгч зөвлөмж дүгнэлт өгсөн. Нийгмийн даатгалын багц хууль, Сайн дурын даатгалын асуудлаар /LIVE/ зөвөлгөө мэдээлэлийг 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр иргэд, даатгуулагчдад хүргэн ажилласан 2024.05.22-ний өдөр Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт шашны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын уулзалт зөвөлгөөнд Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн талаар сургалтыг орж хамралтыг нэмэгдүүлэн ажиллаа 2024.05.25-ний өдөр Улсын их дэлгүүрийн гадна талбайд “Нээлттэй хаалганы өдөрлөг-Зөвлөн тусалья” аяны хүрээнд иргэд даатгуулагч нарт анхан шатны мэргэжил арга зүйн зөвөлгөө өгөн ажиллав. |
| | | | | 2024 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн ..... дугаартай Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, төлөлт, мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг шалгах ажлын удирдамж, шалгах хуваарийн дагуу аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан болон ноогдуулалт, мэдээлэлийн сангийн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3.2.5 | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулах, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож тайлан, мэдээг заасан хугацаанд хүргүүлэх | Дотоодын хяналт шалгалт болон Нийгмийн даатгалын ерөнхий газар, хөндлөнгийн хяналт шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг 2024 оны 06 дугаар сарын 20, 11 дугаар сарын 20-ны өдрийн дотор ХШГ-т хүргүүлнэ. | Шалгалтын үр дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулах | бүрдүүлэлт, даатгуулагчийн төрөл, тайлан авалтын хугацаа, нөхөн тайлангийн үндэслэл болон залруулгын тайлан зэргийг мэдээлэлийн сантай тулган шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр засаж ажиллаж байна.<br>Газрын даргын баталсан удирдамжийн дагуу орлого, шимтгэлийн тасгийн байцаагч М.Мөнх-Эрдэнийн хариуцсан 920 ажил олгогчийн, С.Доржпагамын хариуцсан 100 ажил олгогчийн нийгмийн даатгалын цахим болон цаасан тайланг шалган баталгаажууллаа. Нийгмийн даатгалын ногдуулалт, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, нөхөн тайлангийн үндэслэл ба залруулгын тайлан, улсын байцаагчийн акт зэргийг мэдээллийн сантай тулган шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулан шалгасан.<br>2023 оны Улсын байцаагчийн актыг хадгаламжийн нэгж болгон архивт хүлээлгэн өгөв. |
| | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3.2.6 | Төрийн албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж хэвших. | Хуулийн хугацаанд хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах | Хөрөнгө орлогод орсон их хэмжээний өөрчлөлт болон ажил албан тушаал өөрчлөгдөх үед хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг тухай бүр гаргаж хэвшсэн байна. | Хуулийн хугацаанд гаргаж баталгаажуулсан. |
| 3.2.7 | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журмуудыг хэрэгжүүлэн ажиллах | Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах. | 2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсан зорилтот арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж, хугацаанд нь биелэлтийг гаргасан байна. | 2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгжийн даргатай байгуулж, гүйцэтгэлийн биелэлтийг /эхний хагас жил/ 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр гаргасан. |
| 4.4.3 | Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах | Программ хангамжуудыг зөв зохистой ашиглаж,аюулгүй байдлыг хангах | **SICOS** шинэчлэгдсэн программыг ашиглах | **SICOS** шинэчлэгдсэн программыг ашиглахтай холбоотой дээд гарзаас ирүүлсэн заавар, чиглэлийг мөрдөж ажиллалаа. |

## ХОЁР. НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 2.1.1 | Тогтоогдсон тэтгэмжийг мэдээллийн | Нэгжийн даргын өгсөн үүрэг даалгаврын | |

| | | | |
|---|---|---|---|
| | баазтай тулган шалгаж баталгаажуулах | дагуу эмчийн хяналт хянасан тоогоор | |
| 2.1.2 | ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах | Нэгжийн даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн тоогоор | 2024 оны 11, 12-р сард байгууллага, даатгуулагчтай холбоотой өргөдлийг хүлээн нөхөн тайлантай холбоотой 40, тайлан залруулахтай холбоотой 23 , бусад чиглэлээр 25 өргөдөл, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. |

## ГУРАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | |
|---|---|---|---|
| | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин/ биелэлт |
| “ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ,ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | |
| 1 | Сурах мэдлэгээ дээшлүүлж,сургалтанд хамрагдах. | Хамрагдсан сургалтын тоогоор | Дээд газраас зохион байгуулсан цахим сургалтанд тогтмол хамрагдсан ./5 удаа/ |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЗАХИРГАА ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ В.АЛТАНЗУЛ 2024.12.20